САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХАД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ БА ЦААШДЫН ЗОРИЛТ

МОНГОЛБАНК
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗАР

Эрх зүйн хэрэгжилт, хяналтын
хэлтсийн захирал

А.Туул

Агуулга

Олон улсын болон манай улсын чиг хандлага	3-4
Монгол Улсын банк, санхүүгийн салбар дахь санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах өнөөгийн эрх зүйн орчин	5-6
Олон улсын байгууллагын судалгаа, дүгнэлт, хамтын ажиллагаа	7-8
Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян	9-10
Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төсөл	11-20

Олон улсын чиг хандлага

- 2008 оны Дэлхийн санхүүгийн хямралын дараа санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай асуудал нь санхүүгийн системийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн хөгжилийг дэмжихэд чухал хүчин зүйл гэж үзэн цаашид хөгжүүлэх шаардлагатай гэж үзэх болсон.

- Дэлхийн улс орнууд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тал дээр илүү нухацтай хандаж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхээс эхлээд, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах, бизнесийн сайн арга барилыг мөрдүүлэх, маргааныг боловсронгуй аргаар шийдвэрлэх зэрэг чиглэлээр хурдацтай дэвшлүүдийг хийж эхэлсэн.

Манай улсын чиг хандлага

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалснаар санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангаж, эдийн засагт чухал дэмжлэг үзүүлнэ.

"САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧ" *гэсэн шинэ нэр, томъёог анх удаа гаргаж "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай" хуулиас тусад нь зохицуулахаар болсон.*

Монгол Улсын банкны салбар дахь санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах өнөөгийн эрх зүйн орчин

Зураг 1: Монголын санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүргийн хувиарлалт

Монгол Улсын банк, санхүүгийн салбар дахь санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах өнөөгийн эрх зүйн орчин

Монголбанк нь банкны салбар дахь харилцагч, хадгаламж эзэмжигчийн эрхийг хамгаалах асуудлыг хариуцаж ажилладаг.

Санхүүгийн зохицуулах хороо нь ББСБ, Даатгал, Үнэт цаас, Хадгаламж зээлийн хоршоо зэрэг байгууллагын харилцагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах асуудлыг хариуцаж ажилладаг.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр бүх салбарын хэрэгэлэгчийн эрхийг хамгаалах асуудлыг хариуцаж ажилладаг.

Дээрх гурван байгууллага үүрэг, функцын хувьд давхардал, хийдэл, зөрүүтэй байдаг ба хамтын ажиллагааны механизм байдаггүй.

Олон улсын байгууллагын судалгаа, дүгнэлт

THE WORLD BANK

Дэлхийн банкнаас 2012 оны 10 дугаар сард гаргасан *"Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн суурь боловсролын өнөөгийн байдлын оношлогоо дүгнэлт"*

Судалгааны үр дүн:

Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог үндсэндээ хангалтгүй байна гэж дүгнэсэн.

Олон улсын байгууллагын хамтын ажиллагаа

Харилцан ойлголцлын санамж бичиг

2016.03

Монголбанк АХБ-тай хамтран 2017 онд *"Санхүүгийн салбарын хөгжил, тогтвортой байдлыг дэмжих"* төслийн бүрэлдэхүүн хэсэг болох *"Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь"* төслийг хэрэгжүүлсэн.

САНХҮҮГИЙН
ХЭРЭГЛЭГЧИЙГ
ХАМГААЛАХ АЯН
2018 01.02-05.31
www.mongolbank.mn
@mongolbank.mn
@mongolbank.mn
mongolbank

Аяны талаарх ерөнхий танилцуулга

- **Аяны зорилго**

- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд арилжааны зөв дадлыг төлөвшүүлэх;
- Санхүүгийн хэрэглэгчийн суурь мэдлэгийг дээшлүүлэх.

- **Хийгдсэн ажлууд**

- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид рүү чиглэсэн ажлууд
- Санхүүгийн хэрэглэгчид рүү чиглэсэн ажлууд

- **Үр дүн**

- “Банкны салбарт хэрэглэгчийг хамгааалах нэгдсэн стандарт”
- Санхүүгийн боловсролыг олон нийтэд хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн.

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төсөл

“Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” аяны хэрэгжилтийн үр дүнд Монгол Улс хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагыг харснаар:

*Монголбанкнаас санаачлан “**Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай**” хуулийн төсөл боловсруулахаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж эхлээд байна.*

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төсөл

Global financial inclusion and consumer protection survey, 2017 report, World bank

TABLE 4.1 Approaches to Financial Consumer Protection Legal Frameworks

% of responding jurisdictions that report legal framework approach for financial consumer protection, by income and regional group

LEGAL FRAMEWORK APPROACH	ALL	HIGH INCOME	UPPER-MIDDLE INCOME	LOWER-MIDDLE INCOME	LOW INCOME	EUROPE & CENTRAL ASIA	EAST ASIA & PACIFIC	LATIN AMERICA & CARIBBEAN	MIDDLE EAST & NORTH AFRICA	SOUTH ASIA	SUB-SAHARAN AFRICA
Standalone financial consumer protection law	21%	38%	24%	6%	0%	24%	9%	17%	0%	0%	13%
Consumer protection provisions within other financial sector laws (e.g., banking law)	76%	85%	65%	88%	36%	76%	73%	78%	56%	71%	70%
General consumer protection law with explicit references to financial services	34%	46%	19%	41%	27%	12%	36%	39%	11%	29%	35%
General consumer protection law without explicit reference to financial services	62%	62%	78%	59%	36%	76%	82%	50%	67%	86%	43%
No legal framework exists for financial consumer protection	2%	0%	0%	3%	18%	0%	0%	6%	11%	0%	4%
% of responding jurisdictions with at least two of the four approaches	69%	79%	62%	79%	36%	71%	64%	67%	44%	71%	61%
Number of responding jurisdictions	124	39	37	34	11	17	11	18	9	7	23

Note: The three multi-jurisdiction respondents (Central Bank of West African States or BCEAO, Bank of Central African States or BEAC, and Eastern Caribbean Central Bank or ECCB) are not included in income group classifications. High-income jurisdictions are not included in regional classifications. Jurisdictions were able to select more than one response, for example, a general consumer protection law with explicit references to financial services and consumer protection provisions within other financial sector laws. Twenty-eight responding jurisdictions (23 percent) selected an "other" legal framework not listed in the survey questionnaire.

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төсөл

Өөрийн улсын эдийн засгийн бүтэц, эрх зүйн систем зэрэгт нийцэх дараах улс орны хууль, журмыг судлан тус хуулийн төсөлд тусгах ажлыг хийж байна.

Армения

Киргизстан

Турк

Серб

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн 2 дугаар зүйл, Засгын газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн дагуу Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгох зорилт дэвшүүлсэн.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 5-р зүйл буюу Монголбанкны үйл ажиллагааны чиглэлд ***“банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах”***

/Энэ зүйлийг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төсөл

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А-203 дугаар тушаалаар

“***Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам***” –ыг шинэчлэн баталсан.

Журмын онцлог зохицуулалт:

- Зээлийн бодит өртгийг хэрэглэгчид заавал мэдээллэх;
- Зээлийн хүүг олгох зээлийн дүнгээс урьдчилж суутгахыг хориглох;
- Иргэнд нийлмэл хүүтэй зээл олгохыг хориглох;
- Банк харилцагчийн гомдлыг шийдвэрлэх бүтэцтэй байх.

Хуулийн төслийн зорилго

- *эрх мэдэл, мэдээлэл, нөөц боломжийн тэнцвэргүй байдал;*
- *бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдлэг, боловсролын тэнцвэргүй байдал;*
- *хууль, эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийн тэнцвэргүй байдал.*

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хуулийн төсөл

Санхүүгийн зах зээлийн 95%

Банк бус санхүүгийн байгууллага

Үнэт цаасны компани
Даатгалын компани

Санхүүгийн хэрэглчийг хамгаалах хуулийн төсөл

Хуулийн төслийн ач холбогдол:

- хэрэглэгч нь өөрт тохирсон аливаа санхүүгийн үйлчилгээг өөрийн итгэл үнэмшлээр авахад шаардлагатай мэдлэг, мэдээлэл, боловсролыг үнэ төлбөргүй хангуулах;

- зөрчигдсөн эрхээ эрх бүхий мэргэшсэн байгууллагаар хурдан шуурхай, чирэгдэл багатайгаар шүүхийн бус журмаар шийдвэрлүүлэх,

- санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлагыг ихэсгэсгэх, түүнд тавих төрийн зохицуулагч байгууллагын хяналт, шалгалтыг өндөржүүлэх.

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төсөл

Хуулийн төсөл нь 8-н бүлэгтэй байх ба дараах бүтэцтэй байна.

1-р бүлэг - Нийтлэг үндэслэл,

2-р бүлэг - Санхүүгийн хэрэглэгчийн эрх,

3-р бүлэг - Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, ба хориглох зүйлс,

4-р бүлэг - Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд тавигдах шаарлага ба мэдээллийн ил тод байдал,

5-р бүлэг – Санхүүгийн маргаан шийдвэрлэх,

6-р бүлэг – Санхүүгийн боловсрол,

7-р бүлэг – Бусад заалт, хариуцлага.

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төсөл

“**Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай**” хуулийн төслийн онцлог тал:

- “**Cooling off-period**” санхүүгийн хэрэглэгч зээлийн гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор аливаа торгууль, нэмэлт шимтгэлгүйгээр татгалзах эрх.

- “**Mystery shopping**” төрийн зохицуулагч байгууллагаас санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдаж авах замаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх.

Анхаарал тавьсанд баярлалаа

2018 он